



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/13

Модот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 1.3 дахь заалт, Засгийн газрын 2006 оны 258 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Эрсдлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.4 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 230 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Онцгой байдлын газрын 2026 оны 48/47 дугаар тоот албан бичгийн дагуу Улсын нөөцөөс үнэгүй олгох малын тэжээлийг татан авчирч, малчдад олгосугай

2.Малын тэжээлийг татан авч, малчдад олгох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлтхүүнтэй томилсугай

Ажлын хэсгийн ахлагч Д.Өсөхгэрэл - Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд

Ж.Тодбилэг - Байгаль хамгаалагч

С.Ган-Очир - Засаг даргын Тамгын газрын нярав

3.Уг арга хэмжээнд шаардагдах шатахууны 1.340.000 (Нэг сая гурван зуун дөчин мянган төгрөг)-ийг Эрсдлийн сангийн нөөц зардлаас гаргахыг Санхүүгийн албаны Нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

4.Малын тэжээлийг татах ажлыг зохион байгуулахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайтар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Өсөхгэрэлд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ